



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 5/37

Чингис хот

Б.Мөнгөнцэцэгийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2 дугаар хавсралтын 2, "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, 2014 оны "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Туршилтын хугацаанд хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж, цаашид төрийн жинхэнэ албанд үр бүтээлтэй ажиллаж чадахаа нотлон харуулсан Баатарын Мөнгөнцэцэгийг Архивын тасгийн даргаар 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Мөнгөнцэцэгийн үндсэн цалинг ТЗ-7-2 шатлалаар тогтоож, зэрэг дэвийн нэмэгдлийг 22, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 10 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн даргын ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Мөнгөнцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

03 169